



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 532

Улаанбаатар хот

┌ Хорооны 2008 оны 186 дугаар тогтоолоор ┐
батлагдсан журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2 дахь заалтыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн 186 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 10 дугаар зүйлийн 10 дахь хэсгийн 10.1.3¹ дахь заалт, 10 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 10.4.3¹ дахь заалтыг тус тус нэмсүгэй:

1/ 10 дугаар зүйлийн 10 дахь хэсгийн 10.1.3¹ дахь заалт:

“10.1.3¹ тухайн төрлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг авснаас хойш 3 улирал дараалан үйл ажиллагаа эрхлээгүй”.

2/ 10 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 10.4.3¹ дахь заалт:

“10.4.3¹ тухайн төрлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг авснаас хойш 4 улирал дараалан үйл ажиллагаа эрхлээгүй”.

2. Мөн журмын 10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10.1.1 дэх заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/ 10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10.1.1 дэх заалт

“10.1.1 тухайн үйл ажиллагааны ирүүлбэл зохих санхүүгийн тайлан, мэдээг 6 сар дараалан Хороонд ирүүлээгүй”

3. Мөн журмын 2 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 2.6.7 дахь заалтыг хүчингүй болгосугай.

4. Журамд нэмэлт өөрчлөлтийг оруулж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000903